

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.08.04

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- ТОП-20 индексийн өсөлт 8-р сард үргэлжилнэ
- Голомт болон Төрийн банкны үнэлгээний P/E, P/B харьцаанууд дунджаас доогуур байна.
- МХБ-ийн ашиг эхний хагас жилд 12 тэрбум төгрөгт хүр буурлаа.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.31%	-0.71%	25.47%
MSE A	-0.96%	-1.21%	20.27%
MSE B	0.08%	-0.21%	34.89%

2025/07/28 – 2025/08/01

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	710,152,471.00
QPAY	314,691,253.36
XAC	238,040,173.00
GLMT	141,695,831.76
MFC	99,899,110.58

2025/07/28 – 2025/08/01

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
GTL	55,000.00	22.22%
ONH	20,700.00	15.00%
UNS	15,900.00	14.39%
AMT	9.45	13.72%
BNG	33,000.00	10.00%

2025/07/28 – 2025/08/01

2025 он 08-р сарын 04

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,269

ТОП-20 индекс

49,335

MSE A

17,988

MSE B

14,501

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

2.4%

2024 - I улирал

Инфляц

8.2%

2025-06 сар

ГВУН(сая\$)

5,379.75

2025-07 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,588.79

2025-08-03

Эдийн засгийн мэдээлэл


ТОП 20 ИНДЕКСИЙН ӨСӨЛТ 8-Р САРД ҮРГЭЛЖИЛНЭ



2023 оноос хойших ТОП-20 индексийн гүйцэтгэлийг хараад үзвэл тодорхой циклийн дагуу ханш явсан байна. Жил бүрийн эхний хагас жилд индекс уналттай байдаг бол сүүлийн хагас жилд өсөлт давамгайлж байгаа нь ажиглагдаж байна. Мэдээж энэ нь компаниудын ашиг орлогын тайлантай шууд холбоотой байдаг. 7-р сард ихэнх компаниуд тайлангаа танилцуулж түүнд үндэслэн хөрөнгө оруулагчдын эрэлт нэмэгддэг юм. Харин эхний хагас жилд ногдол ашгийг бүртгэлийн өдөртэй холбоотой ихээр хувьцааг худалдан аван, зарах үйл ажиллагаа өрнөдөг.

Эх сурвалж: Эдийн засаг хөгжлийн яам

Хүснэгт 1. Монгол улсын ГВУН /сая ам.доллар/



Зах зээлийн мэдээлэл

БАНКНУУДЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД




2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангууд гарснаар арилжаалагдаж буй банкуудын үнэ цэнийн үзүүлэлт (valuation metrics) болох P/E, P/B харьцаа болон ROE харьцуулсан судалгааг онцолж байна.

GLMT, SBM банкуудын P/E, P/B аль аль нь зах зээлийн дунджаас доогуур (P/E < 3.8, P/B < 0.8) байгаа нь эдгээр хувьцаанууд үнэлгээний хувьд харьцангуй "хямд" байгааг илтгэнэ.

Ялангуяа GLMT банк нь өндөр ROE (25.8%) хадгалж буй нь хямд үнэлгээтэй ч өгөөж өндөртэй хувьцаа гэж дүгнэхэд хүргэж байна.

P/E, P/B зэрэг үнэлгээний үзүүлэлт багатай хувьцаанууд хямдралтай зарагдаж байгааг илэрхийлэх эхний дохио бөгөөд ирээдүйд эрэлт нэмэгдэхэд үнэ өсөх боломжтой буюу өсөлтийн орон зай хадгалагдсаар байдаг.

МХБ-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АШИГ 12₮ ТЭРБУМ БОЛЖ БУУРАВ



Монголын Хөрөнгийн Бирж ХК (MSE) 2025 оны эхний хагас жилд 12.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Хагас жилийн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд:

Ашгийн бууралт: Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиг нь 5.8 тэрбум төгрөгөөр буюу 33%-иар буурлаа.

Нэгж хувьцааны ашиг (EPS): Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 34.4 төгрөг болсон нь 2024 оны хагас жилийнхээс мэдэгдэхүйц доогуур байна.

Бууралтын шалтгаан: 2025 оны эхний хагаст арилжааны орлого нь саарч, ялангуяа нүүрсний арилжаа эрс хумигдсан нь ашиг буурахад шууд нөлөөлжээ.

Өмнөх үетэй харьцуулахад: 2024 онд MSE түүхэндээ анх удаа улирлын 17.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, арилжааны идэвх нь оргил цэгтээ хүрч байсан юм.


Ирээдүйн төлөв ба эрсдэл: Компанийн зүгээс 2025 онд ашигт ажиллагаа тогтвортой байна гэж төлөвлөсөн ч хагас жилийн гүйцэтгэл нь энэхүү зорилтод хүрэхэд хүндрэлтэй байгааг харуулж байна. Хэрвээ одоогийн хандлага үргэлжилбэл жилийн эцэст ашиг нь 20 тэрбум төгрөгөөс доош буух эрсдэл үүсэж болзошгүй юм.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.